

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батмөнх	Дугаар	1199
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Мандах сум
Төрсөн газар	Мандах сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Өлгий хийд	Сүм хийдийн дугаар	ДГМН 095
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дорноговь аймгийн Мандах сумын Өлгий хийд

За та өөрийгөө эхлээд танилцуулна уу

Батмөнх: За би Дорноговь аймгийн Мандах сумын хийдийн хамба ламаар ажилладаг аа. Би одоо Гандантэгчилэн хийдийн захиргаанд санал хүсэлт гаргах нэг хоёр зүйл байна. Цаашдаа холбоотой ажиллах, монголын сүм хийдийн лам нартай харилцаатай байх. Аа энэ лам нар нь одоо бид нартай ямар үйл ажиллагаа явуулж байна, сүм хийдийн ажил, үйл ажиллагаа ямар байна, цаашдын суралцах газрыг сонгож дахин суралцах талаар нь холбоотой байх өөрсдийн туршлагаа нааш нь дамжуулах ийм ажил байна. Аа Хүүхдийг сурган хүмүүжүүлэх энэ сургалтын талаар дэмжлэг үзүүлмээр байна. Цаашид одоо хичээлээ сонгон суралцах. Курс одоо сонгон суралцуулах энэ сургалтын талаар харилцан уялдаатай байх. Аа бас бид нар энэ хуучин сүм хийдийнхээ барилга байшинг сэргээн босгох, цаашдаа 21 суваргаа барьж эхлэх энэ тал дээр эдийн засгийн туслалцаа, номын туслалцааг өгч бидэнд тусалж өгнө үү гэж уламжилж хэлмээр байна аа. Ийм хүсэлт тавих байна. Манай хийд бол нөгөө бүх тойрсон аймгийн сумдаасаа 100 орчим км-т алс хол нутагладаг болохоороо

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гандан болон аймгийнхаа орчимд байгуулагдсан сүм хийдээрээ сайн очиж чаддаггүй. Тэгээд бид нар очиж уулзая гэхлээр холын хүмүүс учраас тэгээд бас хүн цөөхөн.ийм учраас бид нар очиж уулзах боломжгүй учраас та нар бас энэ талаар бидэнд тусалж бидний үйл ажиллагааг дэмжиж байхыг хүсье. За баярлалаа